



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны ЗАА-ны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/047/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Булган аймаг
2025 он

Дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын албан тушаалын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2580 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Цахим хаяг: Tserenlhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗАА	Захирагчийн ажлын алба
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЭБЦТС	Эрдэнэт Булган цахилгаан түгээх сүлжээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 278

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ХАНГАЛ СУМЫН
ХЯЛГАНАТ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
А.СОД-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны захирагчийн ажлын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны захирагчийн ажлын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Нэмэлт санхүүжилтийн төсвийг зарцуулах төсвийн эрх нээлгэхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангиллыг баримтлаагүй, тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг бодит гүйцэтгэлээр илэрхийлээгүй, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас цалин, томилолт, шатахуунд зориулалт бусаар зарцуулсан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

632502549

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 61 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг аймгийн Засаг даргын 2024 оны А/794 дүгээр тушаалаар 95.0 хувьтай үнэлүүлэн "маш сайн" үнэлгээ авсан байна.

Шалгадагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захиаргчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	467,281.2	459,615.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,181,499.9	5,536,574.2
	Нийт хөрөнгийн дүн	5,648,781.1	5,996,189.2
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,648,781.1	5,996,189.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,648,781.1	5,996,189.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,072,218.1	1,718,665.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	890,951.0	1,371,257.1
	Үйл ажиллагааны үр дүн	2,181,267.1	347,408.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	2,533.8	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	2,178,733.3	347,408.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,470,047.8	5,648,781.1
	Тайлант оны үр дүн	2,178,733.3	347,408.1
	Эцсийн үлдэгдэл	5,648,781.1	5,996,189.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,110,967.5	1,053,909.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	639,938.0	1,023,510.0
	Үйл ажиллагааны ЦМГ	471,029.5	30,399.8
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(471,029.5)	(30,399.8)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(0.0)	(0.0)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	999,137.1
	Урсгал зардал	-	999,137.1
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	999,137.1
	Улсын төсвөөс санхүүжих	-	957,524.2
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	41,612.9

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 13,573.6 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 13,573.6 мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвөөс 11,586.5 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг санхүүжилтээс бууруулах тохируулах бичилт хийгээгүй,
- Түлш шатах тослох материал худалдан авсан НИК, Зайван ХХК-тай тооцоо нийлсэн актыг тулган баталгаажуулахад 1,000.0 мянган төгрөгөөр дутуу буюу өглөгийн үлдэгдэлтэй тооцоо нийлснийг залруулсан,
- Цалингийн зардлыг давтан тооцоолоход ажиллагсадаас авах авлага татварын хэлтэс, НДХ-тэй 988.1 мянган төгрөгийн өглөг, авлагыг дутуу тайлагнасныг залрууллаа.

Аудитаар залруулагдаагүй үлдсэн 9,179.5 мянган төгрөгийн 5 зөрчилд, 2,771.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2,805.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,603.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,737.5 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг дөрвөн албан хаагчид 1,083.9 мянган төгрөгийг зөрүүтэй тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6² дахь заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

2. Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй, төсвийн орлогод 2,134.8 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6² дахь заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас байгууллагын дотоод журамд тусгагдаагүй зориулалт бусаар эрх зүйн мэргэжлээр суралцаж байгаа бичиг хэргийн ажилтаны баклаврын боловсролын сургалтын төлбөр 2,805.0 мянган төгрөгийг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан

Улаанбаатар эрдэм их сургуульруу шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6 дахь заалтыг үндэслэн зөрчлийг арилгах, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага тогтоолоо.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Нэмэлтийн санхүүжилийн данснаас шатахуун, томилолт, бичиг хэргийн материалыг 210801 зардлын эдийн засгийн ангиллаас зориулалт бусаар 3,428.7 мянган төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан журам, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулах эрх нээлгэхдээ зардлын эдийн ангиллын дагуу эрх нээлгэж, зарцуулж хэвших.

Илрүүлэлт 2: Цалингийн зардлаас 174.7 мянган төгрөгийн ажил олгогчийн НДШ-ийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн шилжүүлж, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан журам, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зардлын эдийн ангиллын дагуу зарцуулж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвөөс төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг санхүүжилтээс бууруулах тохируулах бичилт хийгээгүй.	1	11,586.5			1	11,586.5							
Түлш шатах тослох материал худалдан авсан НИК, Зайван ХХК-тай тооцоо нийлсэн актыг тулган баталгаажуулахад дутуу буюу өглөгийн үлдэгдэлтэй тооцоо нийлсэн.	1	1,000.0			1	1,000.0							
Цалингийн зардлыг давтан тооцоолоход ажиллагаадаас авах авлага татварын хэлтэс, НДХ-тэй өглөг, авлагыг дутуу тайлагнасан.	1	988.1			1	988.1							
Дүн	3	13,573.6			3	13,573.6							

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг дөрвөн албан хаагчид зөрүүтэй тооцож олгосон.	1	1,083.9	1	1,083.9								
Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласны урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй, төсвийн орлогод дутуу төвлөрүүлсэн.	1	2,134.8	1	2,134.8								
Хичээл үйлдвэрлэлийн зардлаас байгууллагын дотоод журамд тусгагдаагүй зориулалт бусаар эрх зүйн мэргэжлээр суралцаж байгаа бичиг хэргийн ажилтаны баглаврын боловсролын сургалтын төлбөр төлсөн.	1	2,805.0			1	2,805.0						

Нэмэлтийн данснаас бичиг 210801 ангиллаас зарцуулсан.	санхүүжилтийн шатахуун, томилолт, хэргийн материалыг зардлын эдийн засгийн зориулалт бусаар зарцуулсан.	1	3,428.7					1	3,428.7			
Цалингийн олгогчийн бүлэг шилжүүлж, зарцуулсан	зардлаас НДШ-ийн хооронд гүйлгэн зардлыг гүйлгэн зарцуулсан	1	174.7					1	174.7			
	Дүн	5	9,626.8	2	3,218.7	1	2,805.0	2	3,603.1			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 11-р сарын төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-хөтөлбөр, зориулалт, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал, хагас жилийн санхүүгийн тайланг хугацаа хоцроож мэдээлсэн.								1	-
Дүн	-	-	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Зөрчил илрээгүй.									
Дүн									
Нийт дүн									



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 01/180

Булган сум

АД 6.70253

ЗНА - 2025/047/НА. СТА - ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчийн мөнгөн урамшууллыг зөрүүтэй тооцож, 636,424.00 (зургаан зуун гучин зургаан мянга дөрвөн зуун хорин дөрөв) төгрөгийг гурван албан хаагчдад илүү, 447,516.00 (дөрвөн зуун дөчин долоон мянга таван зуун арван зургаа) төгрөгийг нэг албан хаагчид дутуу олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 51.3-т "Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтагүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Дутуу тооцож олгосон албан хаагчийг урамшууллыг батлагдсан төсвөөс олгож, илүү тооцож олгосон 636,424.00 (зургаан зуун гучин зургаан мянга дөрвөн зуун хорин дөрөв) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 16-ны дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хялганат тосгоны ажлын албаны дарга (Ч.Номин-Эрдэнэ), нягтлан бодогч (Б.Золзаяа) нарт хариуцуулав.

832505605

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТОР

Г.ЦЭРЭНЛХАМ





БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 02/48

Булган сум

А0670х53 ЗУА. 2025/049/11А. 27А. ТУХЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас 2,134,772.00 (хоёр сая нэг зуун гучин дөрвөн мянга долоон зуун далан хоёр) төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж аваагүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 51.3-т "Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоол "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Нэр бүхий гурван албан хаагчдаас хувь хүний орлогын албан татварыг суутгаж аваагүй 2,134,772.00 (хоёр сая нэг зуун гучин дөрвөн мянга долоон зуун далан хоёр) төгрөгийг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь аймгийн төсвийн орлогын 100040051005 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 16-ний дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хялганат тосгоны ажлын албаны дарга (Ч.Номин-эрдэнэ), нягтлан бодогч (Б.Золзая) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

ЖЭНХЦООДОЛ
Г.ЦЭРЭНЛХАМ
ГТ040048 3190269

632505608



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН
ШААРДЛАГА**

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 01/119

Булган сум

АД 6702253

ЗУА - 2025/0417/НА - СТА - ТУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Булган аймгийн Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хичээл үйлдвэрлэлийн зардлаас зориулалт бусаар байгууллагын дотоод журамд байхгүй, баклаврын боловсролын эзэмшихээр эрх зүйн мэргэжлээр суралцаж байгаа бичиг хэргийн ажилтны Улаанбаатар эрдэм их сургууль руу сургалтын төлбөр 2,805,000.00 (хоёр сая найман зуун таван мянга) төгрөгийг төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал, захирагчийн ажлын албаны дотоод журмыг зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.8-т "Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны дарга (Ч.Номин-Эрдэнэ), нягтлан бодогч (Б.Золзаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

Ж.ЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ

632504395